



# ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ\*

2018 оны 12 дугаар сар


**Ерөнхий тойм:** Энэ оны эхний 12 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 22%-иар буюу 2,351 сая ам.доллараар өсч 12,887 сая ам.долларт хүрсэн. Үүнд экспорт 13%-иар буюу 811 сая ам.доллараар, импорт 36%-иар буюу 1,540 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлсөн. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 728 сая ам.доллараар буурч 1,137 сая ам.долларын ашигтай байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 12 сар			Өөрчлөлт			
	2015	2016	2017	2016/2015		2017/2016		2016	2017	2018	2017/2016		2018/2017	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	8,467	8,274	10,536	(192)	-2%	2,262	27%	8,274	10,536	12,887	2,262	27%	2,351	22%
Экспорт	4,669	4,916	6,201	247	5%	1,284	26%	4,916	6,201	7,012	1,284	26%	811	13%
Импорт	3,798	3,358	4,335	(439)	-12%	977	29%	3,358	4,335	5,875	977	29%	1,540	36%
Тэнцэл	872	1,558	1,865	686		307	20%	1,558	1,865	1,137	307	20%	(728)	-39%

**Валютын төлбөртэй худалдааны тэнцэл\*\*** 2018 оны эхний 12 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 551 сая ам.доллараар буурч 1,501 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Зураг 1. Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /3 сарын гулсах дундаж/




Зураг 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



**Хөрш орнуудтай хийсэн худалдааг** авч үзвэл, нийт бараа эргэлтийн 66% буюу 8,475 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 14% буюу 1,796 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 40%-иар, БНХАУ-тай хийсэн худалдаа 28%-иар тус тус өссөн байна.

Зураг 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



**Гадаад худалдааны нөхцөлийн индекс** 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 0.2%-иар, өмнөх сараас 1%-иар өсч 1.754-д хүрлээ. Худалдааны нөхцөл өмнөх сараас сайжирахад зэсийн баяжмалын экспортын үнийн өсөлт голлон нөлөөлөв.

\*Энэхүү тоймыг ГЕГ-ын "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"-д үндэслэн, дэлхийн улс орнуудын Төв банкны практикт нийцүүлж, судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээнд зориулан боловсруулав.

\*\* Нийт худалдааны дүнгээс дахин экспорт/импорт, боловсруулах бараа, бараа солилцоо, хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа, гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа болон бусад барааг хассан дүн болно.

**Экспорт** 2018 оны эхний 12 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 13%-иар буюу 811 сая ам.доллараар өсөв. Үүнд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт өссөн нь нийт экспортыг 11 нэгж хувиар өсгөх чиглэлд нөлөөлөв. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 0.6 хувиар буурсан бол мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын эзлэх хувь 0.7 нэгж хувиар өссөн байна.

**Хүснэгт 3. Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/**

Төрөл	2016			2017			2018			Δ (2017/2016)			Δ (2018/2017)				
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	%²	Дүн	Өсөлт	%²		
<b>1. Уул уурхай</b>		<b>4,238</b>	<b>86%</b>		<b>5,519</b>	<b>89%</b>		<b>6,200</b>	<b>88%</b>		<b>1,280</b>	<b>30%</b>	<b>26%</b>		<b>681</b>	<b>12%</b>	<b>11.0%</b>
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	1,554	1,606	33%	1,447	1,613	26%	1,437	2,012	29%	7	0%	0%	399	25%	6%		
1.2. Чулуун нүүрс	25,607	968	20%	32,990	2,256	36%	35,758	2,786	40%	1,288	133%	26%	530	23%	9%		
1.3. Боловсруулаагүй нефть	7,977	336	7%	7,514	374	6%	6,190	392	6%	38	11%	1%	18	5%	0%		
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	6,425	261	5%	6,258	310	5%	7,449	342	5%	50	19%	1%	32	10%	1%		
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	19,169	758	15%	14,548	595	10%	3,432	144	2%	(163)	-22%	-3%	(451)	-76%	-7%		
1.6. Цайрын хүдэр, баяжмал	126	144	3%	118	181	3%	124	198	3%	37	26%	1%	17	9%	0%		
1.7. Жонош, лейцит, нефелинт	247	59	1%	319	84	1%	555	190	3%	26	44%	1%	106	126%	2%		
1.8. Молибдений хүдэр, баяжмал	6	26	1%	6	37	1%	6	50	1%	11	41%	0%	13	34%	0%		
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	1	10	0%	1	8	0%	1	9	0%	(2)	-20%	0%	1	0%	0%		
1.10. Мөнгө /тонн/	95	39	1%	0	1	0%	0	1	0%	(38)	-98%	-1%	(0)	0%	0%		
1.11. Бусад	133	31	1%	440	58	1%	536	75	1%	27	20x	1%	17	29%	0%		
<b>2. Мал аж, ахуй</b>	<b>208</b>	<b>316</b>	<b>6%</b>	<b>363</b>	<b>379</b>	<b>6%</b>	<b>412</b>	<b>477</b>	<b>7%</b>	<b>63</b>	<b>20%</b>	<b>1%</b>	<b>98</b>	<b>26%</b>	<b>1.6%</b>		
2.1. Амьд мал, малын мах	9	19	0%	29	56	1%	41	87	1%	37	194%	1%	32	57%	1%		
2.2. Арьс, шир	173	24	0%	306	23	0%	342	17	0%	(1)	-6%	0%	(6)	-26%	0%		
2.3. Малын өлөн гэдэс	0	7	0%	0	6	0%	1	9	0%	(0)	-2%	0%	2	0%	0%		
2.4. Ноолуур	7	242	5%	8	262	4%	9	333	5%	20	8%	0%	70	27%	1%		
2.5. Ноос, бусад үс, хялгас	16	22	0%	19	29	0%	15	28	0%	7	33%	0%	(1)	-3%	0%		
2.6. Бусад	1	2	0%	1	2	0%	4	3	0%	0	13%	0%	1	33%	0%		
<b>3. Газар тариалан</b>	<b>136</b>	<b>24</b>	<b>0%</b>	<b>153</b>	<b>14</b>	<b>0%</b>	<b>56</b>	<b>15</b>	<b>0%</b>	<b>(10)</b>	<b>-42%</b>	<b>0%</b>	<b>2</b>	<b>12%</b>	<b>0.0%</b>		
<b>4. Аж үйлдвэрлэл</b>	<b>280</b>	<b>337</b>	<b>7%</b>	<b>360</b>	<b>289</b>	<b>5%</b>	<b>234</b>	<b>319</b>	<b>5%</b>	<b>(49)</b>	<b>-14%</b>	<b>-1%</b>	<b>30</b>	<b>10%</b>	<b>0.5%</b>		
4.1. Хүнс	9	43	1%	19	77	1%	36	92	1%	34	80%	1%	14	19%	0%		
4.2. Ноолууран эдлэл	1	26	1%	1	32	1%	1	35	0%	7	27%	0%	3	8%	0%		
4.3. Бусад хувцас, пүтэл, эдлэл	2	20	0%	3	16	0%	4	25	0%	(3)	-17%	0%	9	54%	0%		
4.4. Уул уурхай	31	88	2%	35	110	2%	61	107	2%	22	25%	0%	(2)	-2%	0%		
4.5. Цахилгаан, электрон бараа	0	5	0%	0	1	0%	0	3	0%	(4)	-77%	0%	2	212%	0%		
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	1	148	3%	2	45	1%	3	52	1%	(103)	-69%	-2%	6	14%	0%		
4.7. Бусад	237	8	0%	300	7	0%	129	5	0%	(2)	-21%	0%	(2)	-25%	0%		
<b>5. Бусад</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>0%</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>0%</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>0%</b>	<b>0</b>	<b>8%</b>	<b>0%</b>	<b>0</b>	<b>3%</b>	<b>0.0%</b>		
<b>Нийт дүн</b>		<b>4,916</b>		<b>6,201</b>			<b>7,012</b>			<b>1,284</b>	<b>26%</b>		<b>811</b>	<b>13%</b>			

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

**Хүснэгт 4. Экспортын өөрчлөлт, 2018 оны 12 дугаар сар**

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо	%	Үнийн	%	Нийт	%
<b>1. Уул уурхай</b>	<b>(199)</b>		<b>880</b>		<b>681</b>	<b>12%</b>
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	(15)	-4%	414	104%	399	25%
1.2. Чулуун нүүрс	216	41%	314	59%	530	23%
1.3. Боловсруулаагүй нефть	(84)	-468%	102	568%	18	5%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	55	(23)	32	10%	32	10%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	(468)	104%	17	-4%	(451)	-76%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	9	53%	8	47%	17	9%
1.7. Жонош, лейцит, нефелинт	81	76%	25	24%	106	126%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	(4)	-32%	17	132%	13	34%
1.11. Бусад	13	80%	3	20%	17	29%
<b>2. Мал аж, ахуй</b>	<b>80</b>		<b>18</b>		<b>98</b>	<b>26%</b>
2.1. Амьд мал, малын мах	25	78%	7	22%	32	57%
2.2. Арьс, шир	2	-29%	(8)	129%	(6)	-26%
2.3. Малын өлөн гэдэс	2	101%	(0)	-1%	2	0%
2.4. Ноолуур	57	80%	14	20%	70	27%
<b>3. Газар тариалан</b>	<b>(27)</b>		<b>28</b>		<b>2</b>	<b>12%</b>
<b>4. Аж үйлдвэрлэл</b>	<b>101</b>		<b>(70)</b>		<b>30</b>	<b>10%</b>
<b>5. Бусад</b>	<b>(1)</b>		<b>0</b>		<b>0</b>	<b>3%</b>
<b>Нийт дүн</b>	<b>(45)</b>		<b>856</b>		<b>811</b>	<b>13%</b>

\* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

**Зураг 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ**



2018 оны эхний 12 сард экспортын гадаад худалдааны тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 45 сая ам.доллараар буурсан бол үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 856 сая ам.доллараар өссөн байна. Чулуун нүүрс, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 201 сая ам.доллараар, үнийн өсөлтөөс шалтгаалж 728 сая ам.доллараар өссөн байна. Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ өссөнөөс шалтгаалж 101 сая ам.доллараар өссөн боловч үнийн өөрчлөлтөөс шалтгаалан 70 сая ам.доллараар буурсан байна.

Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2018 оны 12 дугаар сард 1,253 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 1%-иар буурсан хэдий ч өнгөрсөн сараас 3%-иар өссөн байна. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн дундаж үнэ тайлант сард харгалзан 6,075; 69 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 11%-иар, төмрийн хүдэр 4%-иар, өнгөрсөн сараас зэс 2%-иар, төмрийн хүдэр 6%-иар тус тус буурсан. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 12 дугаар сард 70 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 3%-иар, өмнөх сараас 5%-иар буурсан байна.

**Импорт** 2018 оны эхний 12 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 36%-иар буюу 1,540 сая ам.доллараар өссөн. Импортын өсөлтийг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний өсөлт 16 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний өсөлт 8 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний өсөлт 7 нэгж хувийг, аж үйлдвэрийн орц бүтээгдэхүүний өсөлт 4 нэгж хувийг бүрдүүлж байна.

**Хүснэгт 5.** Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2016			2017			2018			Δ (2017/2016)			Δ (2018/2017)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% <sup>2</sup>	Дүн	Өсөлт	% <sup>2</sup>
<b>Хэрэглээний бүтээгдэхүүн</b>		<b>1,159</b>	<b>35%</b>		<b>1,285</b>	<b>30%</b>		<b>1,643</b>	<b>28%</b>	<b>127</b>	<b>11%</b>	<b>4%</b>	<b>358</b>	<b>28%</b>	<b>8%</b>
Түргэн эдэлгээтэй	823	652	19%	836	733	17%	970	864	15%	81	12%	2%	131	18%	3%
Хүнс	394	453	13%	390	510	12%	463	596	10%	58	13%	2%	86	17%	2%
Эм, тариа	2	90	3%	3	95	2%	3	119	2%	5	5%	0%	24	26%	1%
Бусад түргэн эдэлгээтэй бараа	427	109	3%	443	128	3%	504	149	3%	19	18%	1%	21	17%	0%
Удаан эдэлгээтэй	125	507	15%	199	553	13%	238	779	13%	45	9%	1%	226	41%	5%
Гутал, хувцас, цүнх	44	53	2%	64	64	1%	61	74	1%	11	21%	0%	10	16%	0%
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба тавилга	24	97	3%	71	94	2%	99	120	2%	(3)	-3%	0%	27	28%	1%
Авто машин, түүний салбэг хэрэгсэл	1	294	9%	1	328	8%	2	499	9%	34	12%	1%	171	52%	4%
Бусад удаан эдэлгээтэй бараа	56	63	2%	63	66	2%	77	85	1%	3	5%	0%	18	27%	0%
<b>Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн</b>	<b>1,102</b>	<b>1,152</b>	<b>34%</b>	<b>1,126</b>	<b>1,702</b>	<b>39%</b>	<b>1,458</b>	<b>2,396</b>	<b>41%</b>	<b>550</b>	<b>48%</b>	<b>16%</b>	<b>694</b>	<b>41%</b>	<b>16%</b>
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	17	685	20%	27	1,077	25%	31	1,512	26%	393	57%	12%	435	40%	10%
Суудлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	1	214	6%	1	328	8%	1	442	8%	115	54%	3%	114	35%	3%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	16	471	14%	26	749	17%	30	1,070	18%	278	59%	8%	321	43%	7%
Барилгын материал	691	283	8%	594	441	10%	780	648	11%	159	56%	5%	207	47%	5%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	53	185	6%	58	183	4%	48	236	4%	(2)	-1%	0%	53	29%	1%
<b>Аж үйлдвэрлэлийн орц</b>	<b>1,060</b>	<b>508</b>	<b>15%</b>	<b>1,370</b>	<b>552</b>	<b>13%</b>	<b>1,576</b>	<b>717</b>	<b>12%</b>	<b>44</b>	<b>9%</b>	<b>1%</b>	<b>165</b>	<b>30%</b>	<b>4%</b>
Хүнсний орц	191	53	2%	51	22	0%	282	79	1%	(32)	-60%	-1%	57	266%	1%
Химийн бүтээгдэхүүн	129	86	3%	183	107	2%	207	122	2%	21	24%	1%	15	14%	0%
Даавуу, утас, арьс, савжин эдлэл	28	19	1%	49	23	1%	83	32	1%	4	21%	0%	9	42%	0%
Цахилгаан эрчим хүч	1	124	4%	2	136	3%	2	143	2%	12	10%	0%	7	5%	0%
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	2	1	0%	2	1	0%	1	1	0%	(0)	-30%	0%	(0)	-34%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтай	752	225	7%	839	264	6%	884	341	6%	39	17%	1%	77	29%	2%
<b>Нефтийн бүтээгдэхүүн</b>	<b>1,060</b>	<b>533</b>	<b>16%</b>	<b>1,370</b>	<b>789</b>	<b>18%</b>	<b>1,576</b>	<b>1,112</b>	<b>19%</b>	<b>256</b>	<b>48%</b>	<b>8%</b>	<b>323</b>	<b>41%</b>	<b>7%</b>
Дизель түлш	554	257	8%	805	428	10%	849	577	10%	171	66%	5%	149	35%	3%
АИ-92, АИ-95	330	165	5%	354	211	5%	371	264	4%	46	28%	1%	53	25%	1%
А-80 болон бусад	176	111	3%	211	150	3%	356	272	5%	39	35%	1%	122	81%	3%
<b>Бусад</b>	<b>13</b>	<b>6</b>	<b>0%</b>	<b>16</b>	<b>7</b>	<b>0%</b>	<b>292</b>	<b>7</b>	<b>0%</b>	<b>1</b>	<b>24%</b>	<b>0%</b>	<b>(1)</b>	<b>-11%</b>	<b>0%</b>
<b>Нийт дүн</b>		<b>3,358</b>		<b>4,335</b>			<b>5,875</b>			<b>977</b>	<b>29%</b>		<b>1,540</b>	<b>36%</b>	

%<sup>2</sup> - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

**Хүснэгт 6.** Импортын өөрчлөлт, 2018 он

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	210	59%	147	41%	358	28%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	406	58%	288	42%	694	41%
Аж үйлдвэрлэлийн орц	79	48%	86	52%	165	30%
Нефтийн бүтээгдэхүүн	153	47%	170	53%	323	41%
Дизель түлш	30	20%	119	80%	149	35%
АИ-92, АИ-95	12	23%	41	77%	53	25%
А-80 болон бусад	111	91%	11	9%	122	81%
Бусад	6		(7)		(1)	-11%
<b>Нийт дүн</b>	<b>854</b>	<b>55%</b>	<b>685</b>	<b>45%</b>	<b>1,540</b>	<b>36%</b>

\* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

**Зураг 5.** Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/



2018 оны эхний 12 сарын гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 694 сая ам.доллараар, хэрэглээний бүтээгдэхүүний импорт 358 сая ам.доллараар, нефтийн бүтээгдэхүүний импорт 323 сая ам.доллараар, аж үйлдвэрлэлийн орц бүтээгдэхүүний импорт 165 сая ам.доллараар тус тус өссөнөөр нийт импорт 1,540 сая ам.доллараар өссөн.

Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2018 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 13 хувиар өссөн хэдий ч өмнөх сараас 7 хувиар буурч тонн тутамд 734 ам.долларт хүрэв.